

АУДИТЫН ИРГЭНИЙ ТАНХИМ БОЛОН АУДИТЫН ИРГЭДИЙН БҮЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрмийг Аудитын иргэний танхим болон Аудитын иргэдийн бүлгийн үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, арга зүй, төлөвлөлт, санхүүжилт, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл болон эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцаанд мөрдөнө.

1.2 Энэхүү дүрмийн зорилго нь Монгол Улсын Төрийн аудитын байгууллага болон иргэд, олон нийт, төрийн бус байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох, төрийн аудитын чанар, үр дүнг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог төрийн аудитын үйл ажиллагаанд татан оролцуулах, иргэд, олон нийтэд ил тод нээлттэй үнэн зөв мэдээллийг хүргэхэд оршино.

1.3 Аудитын иргэний танхимын болон Аудитын иргэдийн бүлгийн үйл ажиллагаа нь Төрийн аудитын байгууллагуудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн аудитын сэдвийн талаар ард, иргэдийн саналыг авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, саналыг нэгтгэн дүн шинжилгээ хийхэд чиглэнэ.

1.4 Монгол Улсын Ерөнхий аудитор, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэд Аудитын иргэний танхим, Аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэд Аудитын иргэдийн бүлэг орон тооны бус бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулна.

1.5 Монгол Улсын Ерөнхий аудитор, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим болон Аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэдийн бүлгийн гишүүн нь Монгол Улсын иргэн байх, 10-аас дээш жил ажилласан туршлагатай байх, эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, хууль, төрийн захиргаа болон холбогдох бусад чиглэлээр боловсролын зэрэгтэй байх, ял шийтгүүлж байгаагүй, төрийн аудитын байгууллагын бүрэн эрхэд харшлах аливаа ажил, албан тушаал давхар эрхэлдэггүй, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, мэргэжлийн болон төрийн бус байгууллагад санхүүгийн сонирхолгүй байх шаардлагыг хангасан байна.

1.6 Аудитын иргэний танхим болон Аудитын иргэдийн бүлэг, тэдгээрийн нэгжид ажиллах гишүүдийг сонгохдоо Төрийн аудитын байгууллага нээлттэй ил тод байдлаар зарлаж, сонгон шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ.

Хоёр. Аудитын иргэний танхим болон Аудитын иргэдийн бүлгийн ажиллах зарчим

2.1. Аудитын иргэний танхимын болон Аудитын иргэдийн бүлэг нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 2.1.1. хүнлэг энэрэнгүй байх;
- 2.1.2. хууль дээдлэх;
- 2.1.3. шударга байх;
- 2.1.4. ил тод, нээлттэй байх;
- 2.1.5. төрийн аудитын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 2.1.6. иргэд, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах.

Гурав. Аудитын иргэний танхим болон Аудитын иргэдийн бүлгийн эрх, үүрэг.

3.1. Аудитын иргэний танхим болон Аудитын иргэдийн бүлэг дараах эрхтэй байна. Үүнд:

3.1.1. тухайн жилийн аудит хийх сэдэв, төлөвлөгөөний төсөлд өөрийн болон иргэдийг төлөөлөн саналаа өгөх;

3.1.2. Үндэсний аудитын газар болон Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын Аудитын зөвлөлийн хуралдааны хэлэлцэх асуудлуудад урьдчилан саналаа өгөх;

3.1.3. иргэд, олон нийтийн санал, гомдлын дагуу авсан арга хэмжээ, үр дүнтэй танилцах;

3.1.4. Төрийн аудитын байгууллагаас гарсан аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн талаар иргэд, олон нийтэд энгийн ойлгомжтой мэдээлэл хүргэх, хэлэлцүүлэг зохион байгуулах.

3.2. Аудитын иргэний танхим болон Аудитын иргэдийн бүлгийн гишүүд дараах үүрэгтэй байна. Үүнд:

3.2.1. Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд ажиллах;

3.2.2. асуудалд үнэнч шударга, бодитой хандах;

3.2.3. нууцыг чандлан хадгалах;

3.2.4. Төрийн аудитын байгууллагад болон иргэд, олон нийтэд үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй тайлагнах.

3.3. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим болон иргэдийн бүлэг нь аудитын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Монгол Улсын Ерөнхий аудиторын дэргэдэх Аудитын иргэний танхимд болон Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газарт санал хүргүүлж болно.

3.4. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим болон иргэдийн бүлгийн үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий аудиторын дэргэдэх Аудитын иргэний танхим болон Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газар арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

3.5. Монгол Улсын Ерөнхий аудиторын дэргэдэх Аудитын иргэний танхим нь Монгол Улсын Ерөнхий аудиторт нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим нь Нийслэлийн дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторт, Аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэдийн бүлэг нь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторт хагас жилийн тайланг тухайн оны 6 дугаар сарын 15-ны дотор, бүтэн жилийн тайланг тухайн оны 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж танилцуулна.

3.6. Монгол Улсын Ерөнхий аудитор, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим болон Аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын иргэдийн бүлэг нь иргэд, олон нийтэд хагас, бүтэн жилээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг гаргаж тайлагнана.

Дөрөв. Монгол Улсын Ерөнхий аудиторын дэргэдэх Аудитын иргэний танхимын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, төсөв санхүүжилт

4.1. Монгол Улсын Ерөнхий аудиторын дэргэдэх Аудитын иргэний танхим нь Монгол Улсын Ерөнхий аудиторын Зөвлөх болон салбар бүрийн орон тооны бус зөвлөлийн зөвлөх буюу шинжээч нараас бүрдсэн 8 хүн нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

4.2. Монгол Улсын Ерөнхий аудитор, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим, Аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэдэх

Аудитын иргэдийн бүлэг нь тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх бөгөөд энэ нь тухайн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан байна.

4.3. Монгол Улсын Ерөнхий аудиторын дэргэдэх Аудитын иргэний танхим нь Монгол Улсын Ерөнхий аудиторын Зөвлөх /цаашид "Зөвлөх" гэх/-ийн удирдлагад үйл ажиллагаагаа явуулах бөгөөд мэргэжлийн болон шаардлагатай гэж үзсэн аудитын сэдэв, түүнтэй холбогдох асуудлын хүрээнд санал, зөвлөмжийг боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулна.

4.4. Монгол Улсын Ерөнхий аудиторын дэргэдэх Аудитын иргэний танхим нь улиралд нэг удаа бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдана. Шаардлагатай тохиолдолд Монгол Улсын Ерөнхий аудиторын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тодорхой сэдвийн хүрээнд дүгнэлт гарган, санал, зөвлөмж боловсруулах зорилгоор хуралдана. Хуралдааны шийдвэр нь хурлын тэмдэглэл байна.

4.5. Аудитын иргэний танхим нь орон тооны бус зөвлөлийн бүтэцтэйгээр дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:

4.5.1. банк, санхүү, эдийн засгийн;

4.5.2. үйлдвэр, дэд бүтцийн;

4.5.3. нийгэм, боловсрол, соёл, байгаль орчин, эрүүл мэндийн;

4.5.4. хууль, эрх зүйн;

4.5.5. иргэний нийгмийн байгууллагуудын.

4.6. Банк, санхүү, эдийн засгийн орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

4.6.1. зөвлөл нь Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, тухайн жилийн төсвийн төсөл болон төрөөс мөнгөний талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл зэрэг макро-эдийн засгийн талаар Засгийн газар, УИХ-аар батлан гаргах баримт бичгүүдийн төслүүдэд иргэдийн саналыг авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, саналыг нэгтгэх замаар Аудитын иргэний танхимд хүргүүлнэ.

4.6.2. зөвлөл нь Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд болон Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, эргэж төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, гадаад, дотоод зээл, өр төлбөр, түүний ашиглалт, зарцуулалт, үр дүнгийн талаар иргэд, олон нийтийн, төрийн бус байгууллагууд болон мэргэжлийн байгууллагуудын санал, зөвлөмжийг хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж Аудитын иргэний танхимд хүргүүлнэ.

4.6.3. зөвлөл нь макро-эдийн засгийн зөвлөх шинжээч, банкны зөвлөх шинжээч, санхүүгийн зөвлөх шинжээч, татварын зөвлөх шинжээч, дотоод аудит, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх шинжээч, даатгалын зөвлөх шинжээч нараас бүрдэнэ.

4.7. Үйлдвэр, дэд бүтцийн орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

4.7.1. зөвлөл нь хөнгөн болон хүнд аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, аялал, жуулчлал, геологи уул уурхай, эрдэс баялаг, хөдөө аж ахуй, газар тариалан, эрчим хүч, зам тээвэр, иргэний агаарын тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн технологи, барилга, хот төлөвлөлт, газрын харилцаа болон тэдгээртэй адилтгах бусад чиглэлийн үйл ажиллагаанд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон дэд бүтцийн шинж чанартай хөрөнгө оруулалтын

төсөл хөтөлбөрүүдэд мэргэжлийн дүн шинжилгээ хийж, Аудитын иргэний танхимд хүргүүлнэ.

4.7.2. зөвлөл нь бизнес, аж үйлдвэрийн зөвлөх шинжээч, эрчим хүчний зөвлөх шинжээч, авто зам, гүүр, барилга байгууламжийн зөвлөх шинжээч, иргэний агаарын тээвэр, тээврийн зөвлөх шинжээч, холбооны зөвлөх шинжээч, уул, уурхай, хүнд үйлдвэрийн зөвлөх шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

4.8. Нийгэм, боловсрол, соёл, байгаль орчин, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

4.8.1. зөвлөл нь эрүүл мэнд, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, ажиллах хүч, байгаль орчин, боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, нийтийн биеийн тамир, спорт болон тэдгээртэй адилтгах бусад чиглэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн дүн шинжилгээ хийж, Аудитын иргэний танхимд хүргүүлнэ.

4.8.2. зөвлөл нь боловсрол, соёл урлаг, шинжлэх ухааны зөвлөх шинжээч, эрүүл мэндийн зөвлөх шинжээч, хөдөлмөр, нийгмийн хамгааллын зөвлөх шинжээч, нийгмийн даатгалын зөвлөх шинжээч, байгаль орчны зөвлөх шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

4.9. Хууль, эрх зүйн орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

4.9.1. зөвлөл нь төрийн захиргааны төв байгууллагууд, төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудал, тэдгээрийн чиг үүргүүд, батлан хамгаалах, хууль сахиулах, шүүх прокурорын байгууллагууд болон тэдгээртэй адилтгах бусад чиглэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн дүн шинжилгээ хийж, Аудитын иргэний танхимд хүргүүлнэ.

4.9.2. зөвлөл нь хууль, эрх зүйн бодлогын зөвлөх шинжээч, батлан хамгаалах чиглэлийн зөвлөх шинжээч, хууль сахиулах чиглэлийн зөвлөх шинжээч, шүүх, прокурорын зөвлөх шинжээч, төрийн захиргааны зөвлөх шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

4.10. Иргэний нийгмийн байгууллагуудын орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

4.10.1. зөвлөл нь Төрийн аудитын байгууллагын бодлого, үйл ажиллагаа, эрх зүйн орчны талаар болон төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, төсөв, санхүүтэй холбоотой аудитын сэдвийн талаар иргэдтэй санал солилцох, хэлэлцүүлэг, уулзалт, ярилцлага зохион байгуулах, нэгтгэн дүн шинжилгээг хийж, Аудитын иргэний танхимд хүргүүлнэ.

4.10.2. зөвлөл нь төрийн бус байгууллагуудын төлөөлөл, хүүхэд залуучуудын байгууллагын төлөөлөл, эмэгтэйчүүдийн төлөөлөл, ахмадын төлөөлөл, шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагуудын төлөөлөл гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

4.11. Аудитын иргэний танхимын өдөр тутмын үйл ажиллагааг нарийн бичгийн дарга гүйцэтгэх бөгөөд энэ нь Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газрын сургалт, судалгаа хариуцсан шинжээч байна.

4.12. Аудитын иргэний танхимын үйл ажиллагааны жилийн төсвийг Үндэсний Аудитын газрын жил бүрийн төсөвт тусган батлуулах бөгөөд төсөв, санхүүжилтийг Үндэсний Аудитын газрын Тамгын газар зохих журмын дагуу тухай бүр шийдвэрлэж байна.

4.13. Аудитын иргэний танхимын орон тооны бус зөвлөх шинжээч нар болон Аудитын иргэдийн бүлгийн зөвлөх шинжээч нарыг арга зүйн удирдлагаар ханган, сургалт, семинарт жил бүр хамруулах үйл ажиллагааг Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газар хариуцан зохион байгуулна.

Тав. Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхимын, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, төсөв санхүүжилт

5.1. Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим нь Нийслэл дэх Төрийн аудитын газрын Дэд дарга бөгөөд Тэргүүлэх аудитор болон салбар бүрийн орон тооны бус зөвлөлөөс 1-2 зөвлөх буюу шинжээч нараас бүрдсэн 8 хүн, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

5.2. Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим нь Нийслэл дэх Төрийн Аудитын газрын Дэд дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын /цаашид "Дэд дарга" гэх/-ийн удирдлаган дор үйл ажиллагаагаа явуулах бөгөөд мэргэжлийн болон шаардлагатай гэж үзсэн аудитын сэдэв, түүнтэй холбогдох асуудлын хүрээнд санал, зөвлөмжийг боловсруулан Дэд даргад танилцуулан Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторт хүргүүлнэ.

5.3. Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим нь улиралд нэг удаа бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдана. Шаардлагатай тохиолдолд Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тодорхой сэдвийн хүрээнд дүгнэлт гарган, санал, зөвлөмж боловсруулна. Хуралдааны шийдвэр нь хуралдааны тэмдэглэл байна.

5.4. Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхим нь орон тооны бус зөвлөлийн статустайгаар дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:

5.4.1. нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалт, төрийн байгууллагуудын;

5.4.2. үйлдвэр, дэд бүтцийн;

5.4.3. нийгэм, боловсрол, байгаль орчин, эрүүл мэндийн;

5.4.4. төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын;

5.4.5. иргэний нийгмийн байгууллагуудын.

5.5. Нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалт, төрийн байгууллагуудын орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

5.5.1. зөвлөл нь нийслэлийн тухайн жилийн төсвийн төсөл болон нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл зэрэг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлан гаргах баримт бичгүүдийн төслүүдэд иргэдийн саналыг авах, хэлэлцүүлэг зохион байгуулах, саналыг нэгтгэх замаар санал, зөвлөмжийг боловсруулан Дэд даргаар дамжуулан Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторт хүргүүлнэ.

5.5.2. зөвлөл нь Нийслэлийн тусгай зориулалтын сан, хөтөлбөр, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэг, эргэж төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, гадаад, дотоод зээл, өр төлбөр, түүний ашиглалт, зарцуулалт, үр дүнд иргэд, олон нийтийн, төрийн бус байгууллагууд болон мэргэжлийн байгууллагуудын санал, зөвлөмжийг хүлээн авч нэгтгэн, дүн шинжилгээ хийж Дэд даргад танилцуулан Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторт хүргүүлнэ.

5.5.3. зөвлөл нь эдийн засгийн зөвлөх шинжээч, банкны зөвлөх шинжээч, санхүүгийн зөвлөх шинжээч, татварын зөвлөх шинжээч, дотоод аудит, нягтлан бодох бүртгэлийн зөвлөх шинжээч, даатгалын зөвлөх шинжээч нараас бүрдэнэ.

5.6. Үйлдвэр, дэд бүтцийн орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

5.6.1. зөвлөл нь хөнгөн ба хүнд аж үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, аялал, жуулчлал, геологи уулуурхай, эрдэс баялаг, хөдөө аж ахуй, газар тариалан, эрчим хүч, зам тээвэр, иргэний агаарын тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн технологи, барилга, хот төлөвлөлт, газрын харилцаа болон тэдгээртэй адилтгах бусад чиглэлийн үйл ажиллагаанд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллага болон дэд бүтцийн шинж чанартай хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдэд мэргэжлийн дүн шинжилгээ хийж, Дэд даргад танилцуулан Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторт хүргүүлнэ.

5.6.2. тус зөвлөл бизнес, аж үйлдвэрийн зөвлөх шинжээч, эрчим хүчний зөвлөх шинжээч, авто зам, гүүр, барилга байгууламжийн зөвлөх шинжээч, иргэний агаарын тээвэр, тээврийн зөвлөх шинжээч, холбооны зөвлөх шинжээч, уул, уурхай, хүнд үйлдвэрийн зөвлөх шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

5.7. Нийгэм, боловсрол, соёл, байгаль орчин, эрүүл мэндийн орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

5.7.1. зөвлөл нь эрүүл мэнд, нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, ажиллах хүч, байгаль орчин, боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, нийтийн биеийн тамир, спорт болон тэдгээртэй адилтгах бусад чиглэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн дүн шинжилгээ хийж, Дэд даргад танилцуулан Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторт хүргүүлнэ.

5.7.2. зөвлөл нь боловсрол, соёл-урлаг, шинжлэх ухааны зөвлөх шинжээч, эрүүл мэндийн зөвлөх шинжээч, хөдөлмөр, нийгмийн хамгааллын зөвлөх шинжээч, нийгмийн даатгалын зөвлөх шинжээч, байгаль орчны зөвлөх шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

5.8. Төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

5.8.1. зөвлөл нь төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагууд, төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудал, тэдгээрийн чиг үүргүүд, бусад чиглэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн дүн шинжилгээ хийж, Дэд даргад танилцуулан Нийслэл дэх Төрийн Аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторт хүргүүлнэ.

5.8.2. зөвлөл нь хууль, эрх зүйн бодлогын зөвлөх шинжээч, төрийн захиргааны зөвлөх шинжээч гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

5.9. Иргэний нийгмийн байгууллагуудын орон тооны бус зөвлөл нь дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

5.9.1. зөвлөл нь төрийн аудитын байгууллагын бодлого, үйл ажиллагаа, эрх зүйн орчны талаар болон төрийн байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, төсөв, санхүүтэй холбоотой аудитын сэдвийн талаар иргэдтэй санал солилцох, хэлэлцүүлэг, уулзалт, ярилцлага зохион байгуулах, олон нийтийн анхааралд байгаа үнэн зөв хариу хүссэн аудитын сэдвийн талаар иргэдийн саналыг авч нэгтгэн Дэд даргад танилцуулан Нийслэл дэх Төрийн Аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторт хүргүүлнэ.

5.9.2. иргэний нийгмийн байгууллагуудын орон тооны бус зөвлөл нь төрийн бус байгууллагуудын төлөөлөл, хүүхэд залуучуудын байгууллагын төлөөлөл, ахмадын төлөөлөл, шударга өрсөлдөөн

хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагуудын төлөөлөл гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

5.10. Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхимын үйл ажиллагааг нарийн бичгийн дарга гүйцэтгэх бөгөөд энэ нь Нийслэлийн Төрийн аудитын газрын сургалт, судалгаа хариуцсан шинжээч байна.

5.11. Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхимын үйл ажиллагааны тухайн жилийн төсвийг Нийслэл дэх Төрийн Аудитын газрын тухайн жилийн төсөвт тусгах бөгөөд төсөв, санхүүжилтийн үйл ажиллагааг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Тамгын хэлтэс зохиох журмын дагуу тухай бүр шийдвэрлэж байна.

5.12. Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэний танхимын орон тооны бус зөвлөх шинжээч нарыг арга зүйн удирдлагаар ханган, сургалт, семинарт жил бүр хамруулах үйл ажиллагааг Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газар болон Нийслэл дэх Төрийн аудитын газрын Тамгын хэлтэс зохион байгуулж байна.

Зургаа. Аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэдийн бүлгийн зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, төсөв санхүүжилт

6.1. Аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэдэх Аудитын иргэдийн бүлэг /цаашид "Аудитын иргэдийн бүлэг" гэх/ нь Аудитын иргэдийн нэгжтэй байх бөгөөд Аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер болон Аудитын иргэдийн нэгж бүрээс 1-2 хүн төлөөллөөс бүрдсэн 6 хүн нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй байна.

6.2. Аудитын иргэдийн бүлэг нь тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд энэ нь Аймаг дахь Төрийн Аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан байна.

6.3. Аудитын иргэдийн бүлэг нь Аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежерийн удирдлагад үйл ажиллагаагаа явуулах бөгөөд мэргэжлийн болон шаардлагатай гэж үзсэн аудитын сэдвийн хүрээнд санал, зөвлөмжийг менежерт танилцуулан Аймаг дахь Төрийн аудитын газрын даргад хүргүүлнэ.

6.4. Аудитын иргэдийн бүлэг нь улиралд нэг удаа бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдана. Шаардлагатай тохиолдолд Аймаг дахь Төрийн аудитын газрын даргын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тодорхой сэдвийн хүрээнд дүгнэлт гарган, санал, зөвлөмж боловсруулах зорилгоор хуралдана. Хуралдааны шийдвэр нь хурлын тэмдэглэл байна.

6.5. Аудитын иргэдийн бүлгийн хэвийн үйл ажиллагааг нарийн бичгийн дарга гүйцэтгэх бөгөөд энэ нь Аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор байна.

6.6. Аудитын иргэдийн бүлэг нь тухайн орон нутгийн төсвийг боловсруулах, хянах, хэрэгжүүлэх, батлах үйл явцад олон нийтийн оролцоог хангаж байгаа эсэхэд хяналт, тавьж арга зүйн тусламж үзүүлнэ.

6.7. Аудитын иргэдийн бүлэг нь иргэдийн төлөөллөөс бүрдэх бөгөөд үйлчлүүлэгч, ашиг сонирхол нь хөндөгдөж буй иргэд, эцэг эхийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

6.8. Аудитын иргэдийн бүлэг нь орон тооны бус нэгжийн бүтэцтэйгээр дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:

6.8.1. цэцэрлэгийн аудитын иргэдийн нэгж;

6.8.2. сургуулийн аудитын иргэдийн нэгж

6.8.3. эрүүл мэнд, спорт, соёлын аудитын иргэдийн нэгж;

6.8.4. нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн аудитын иргэдийн нэгж;

6.8.5. нутгийн өөрөө удирдах байгууллагын болон нутгийн захиргааны байгууллагуудын аудитын иргэдийн нэгж

6.8.6. уул уурхайн, дэд бүтэц, байгаль орчны аудитын иргэдийн нэгж

6.8.7. банк, санхүү эдийн засгийн аудитын иргэдийн нэгж

6.9. Аудитын иргэдийн нэгжид багтах гишүүдийн тоо нь тухайн орон нутаг дахь төрийн байгууллагуудын тоо, үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан тооны хувьд харилцан адилгүй байж болох бөгөөд 5-аас доошгүй байна.

6.10. Аудитын иргэдийн нэгж нь аудитын ахмад ажилтнуудаас бүрдсэн хөндлөнгийн шинжээчдийн баг байх ба дараах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулна.

6.10.1. тухайн орон нутгийн төсвийн үе шат бүрт иргэдийн оролцоог хангаж байгаа эсэхэд дүгнэлт зөвлөмж гаргах;

6.10.2. төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;

6.10.3. төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд дүгнэлт гаргах;

6.10.4. төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавихад анхаарч ажиллах;

6.10.5. хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;

6.10.6. төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн зтусгасан тухай, төсвийн үйл ажиллагаан дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг иргэдэд тухай бүр мэдээлж байх.

6.11. Аудитын иргэдийн бүлэг нь орон нутгийн төсвийн байгууллагууд иргэд олон нийтийн хэрэгцээ, шаардлагыг хангаж байгаа эсэхэд болон төсвийн зарцуулалтад тавих иргэдийн хяналтыг сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

6.12. Аудитын иргэдийн бүлгийн төсөв санхүүжилтийг Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д заасан зохицуулалтын хүрээнд болон Аймаг дахь Төрийн аудитын газрын төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.

Долоо. Дүрэм зөрчигчид хүлээлгэх хариуцлага

7.1. Аудитын иргэний танхим болон Иргэдийн бүлгийн үйл ажиллагаанд оролцогч нь хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан дүрэм, журам, энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

—○○○—